



ТЕНДЕРТ ОРОЛЦОХЫГ СОНИРХОГЧ  
ЭТГЭЭДЭД

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ  
ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ  
ГАЗАР

Нийслэлийн засаг захиргааны IV байр,  
4 дүгээр хороо, Чингэлтэй дүүрэг,  
Улаанбаатар хот, 15160-0066  
Утас:(976) 7575 7807, Факс: (976) 7575 7809  
Цахим шуудан: contact@ub-procurement.mn  
Цахим хаяг: www.ub-procurement.mn

2024.04.03 № 03/487

танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

Тодруулгын хариу хүргүүлэх тухай

Нийслэлийн Засаг даргын 2024 оны А/118 дугаар захирамжаар эрх шилжин ирсэн НХААГ/20240103244 дугаартай Нийслэлийн 2024 оны төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлэх сайжруулсан шахмал түлш тээвэрлэх-1 үйлчилгээний тендерт оролцохыг сонирхогч этгээдээс ирүүлсэн тодруулгад дараах тайлбарыг хүргүүлж байна. Үүнд:

№	Сонирхогч этгээдийн тодруулга	Захиалагчийн тодруулгын хариу
1	Танай байгууллагаас зарласан НХААГ/20240103244 тендер шалгаруулалтын дугаартай “Нийслэлийн 2024 оны төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлэх сайжруулсан шахмал түлш тээвэрлэх-1”, болон НХААГ/20240103245 тендер шалгаруулалтын дугаартай Нийслэлийн 2024 оны төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлэх сайжруулсан шахмал түлш тээвэрлэх-2 тендерүүдэд оролцохоор бүртгүүлсэн. Уг тендерийн материалын ТШЗ 19.1 дүгээрт заасан ачааны машины хүчин чадал 5-10 тонн гэсэн нь тухайн машины улсын бүртгэлийн гэрчилгээнд заасан үндсэн даацын хэмжээ эсвэл тухайн машинд ачиж болох хэмжээний аль нь болохыг тодруулж өгнө үү.	Монгол Улсын “Авто тээврийн тухай хууль”, “Авто замын тухай хууль”, “Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль” эрх бүхий байгууллагаас батлан гаргасан дүрэм, журам, стандартын дагуу тооцно.

Тодруулгын хариуг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.3 дахь заалтын дагуу цахим системд нээлттэй байршуулж байна.

Тус газраас зарласан тендер шалгаруулалтад амжилттай оролцохыг хүсье.